

Golomt Capital®

БОНДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.05.07



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.125%	6.03%
Монгол 27	2027.07.07	3.50%	7.01%
Хүннү	2028.01.19	8.65%	6.93%
Монгол 29	2029.06.05	7.875%	7.40%
Монгол 30	2030.02.25	6.625%	7.41%
Монгол 31	2031.07.07	4.45%	7.56%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын Засгийн газар бондуудын өгөөж 6.03%-7.56% хооронд хэлбэлзэж байна.



КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	11.08%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	12.24%
MMC	2026.09.13	12.50%	6.85%
DBM	2026.03.07	11.00%	8.75%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 6.85%-12.07%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
{ТУСГАЙ САНАЛ 30%}**

☎ 8083-6622 | 8888-9183 | 8665-4422 | 8083-9944



АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

АНУ-ын доллар 3 жилийн доод түвшинд хүрч, АНУ-ын бондуудын үнэ унаснаар өгөөж өсөж, хөрөнгийн зах зээл уналттай тулгарлаа. Бондын үнэ унах, зах зээл унах хоёр зэрэг явагдах нь АНУ-аас зугатах хөдөлгөөн гэж харж болохоор юм. Дональд Трамп худалдааны дайнаас үүдэлтэй бондын зах зээлийн тогтворгүй байдал, засгийн газрын бондын өгөөжийн огцом өсөлтийн сөрөг нөлөөллөөс шалтгаалан улс орнуудад ногдуулсан тарифыг 90 хоногоор хойшлуулах болжээ.

График 1. АНУ-ын урт хугацаат бондын өгөөж



Бондын өгөөжийн өсөлт нь АНУ-ын төсөвт дарамт учруулж, өрхийн болон тэтгэврийн сангуудыг алдагдалд хүргэж болзошгүй тул улс төрийн нөхцөл байдлыг харгалзан энэхүү шийдвэрийг гаргасан байна. Америкийн засгийн газрын урт хугацааны бондын (T-Bills) өгөөж нь 5.05% хүртэл өссөн билээ.

Эх сурвалж: Tradingview

АНУ-ын Засгийн газрын бондын зах зээл эдийн засгийн үзүүлэлтүүдийн олон дараалсан мэдээлэлд хариу үйлдэл үзүүлж, долоо хоногийн турш хэлбэлзэлтэй байлаа. Ихэнх хугацаат бондын өгөөж пүрэв гараг хүртэл ерөнхийдөө буурсан ч, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт хүлээлтээс давсан тул баасан гарагт өсөлттэй хаагдав. Өндөр өгөөжтэй (high yield) бондын зах зээлд хязгаарлагдмал нийлүүлэлт болон эерэг хөрөнгийн урсгалаас шалтгаалан техникийн дэмжлэг бий болсон. Гэвч Саудын Араб газрын тосны олборлолтоо нэмэгдүүлж болзошгүй талаар дохио өгсний дараа эрчим хүчний салбарын бондууд дарамтад орсон байна.

БНХАУ эдийн засгаа дэмжихийн тулд бодлогын хүүг 10, банкны заавал байлгах нөөцийг 50 нэгжээр буурууллаа

БНХАУ-ын Төв банк өнөөдөр өглөө эдийн засгийн өсөлтийг дэмжих цогц арга хэмжээ зарлалаа.

- 7 хоногийн репо хүү 1.5 %-иас 1.4 % болж 10 суурь нэгжээр буурч, зээлийн үндсэн хүүг мөн адил хэмжээгээр доош татах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Банкны заавал байлгах нөөцийн хувь 50 суурь нэгжээр буурах бөгөөд ингэснээр зах зээлд ойролцоогоор 1,000 тэрбум юанийн шинэ хөрвөх чадвар нэмэгдэнэ.

Яагаад энэ нь чухал вэ?

1. Хүү, нөөцийн бууралт – Зээлжих өртөг буурч, банкны зээл олголт нэмэгдэхээр байна.
2. Зах зээлийн хөрвөх чадвар – 1 их наяд юанийн шинэ хөрөнгө орж ирснээр компаниудын эргэлтийн хөрөнгийн хүндрэл багасна.



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Биржийн бус зах зээлийн долоо хоногийн арилжааны тойм

2025 оны 4 дүгээр сарын 28-наас 5 дугаар сарын 2-ны хооронд Биржийн бус зах зээлд нийт 90,866 ширхэг үнэт цаас 49,118,739,299 төгрөг, 206 ширхэг үнэт цаас 206,529.64 ам.долларын үнийн дүнтэйгээр арилжаалагдсан байна.

Үүнээс анхдагч зах зээлд 43,800 ширхэг үнэт цаасыг 24,540,000,000 төгрөгөөр, мөн 67 ширхэг үнэт цаасыг 67,000.00 ам.доллараар тус тус арилжжээ.

Харин хоёрдогч зах зээлд 47,066 ширхэг үнэт цаас 24,578,739,299 төгрөг, 139 ширхэг үнэт цаас 139,529.64 ам.доллараар арилжаалагдсан байна.


Эх сурвалж: Otc.mn

Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



4 САРЫН
ОНЦЛОХ БОНД

